



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 9/61

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/33 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журам”-ын 2.5-д заасан “... үр дүнг судлан, дүгнэлт саналаа ХАБЭА-н Үндэсний хорооны хуралд танилцуулж, гэрчилгээг энэ журмын 2.4-д заасан хугацаагаар сунгана.” гэснийг “... үр дүнг судлан, сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Уг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан холбогдох тайланг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.” гэж өөрчилсүгэй.

САЙД С.ЧИНЗОРИГ